



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/1208

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 62 дугаар, 2022 оны 223 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр, 2022 оны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай агуулахын нэмэлт зардлыг сайжруулсан шахмал түлшний батлагдсан төсвөөс шийдвэрлэн санхүүжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар), Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд)-т тус тус зөвшөөрсүгэй.

2.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч 3.Төмөртөмөөд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



111020005628